

# Монгол Улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаа

Засгийн газрын авлигатай тэмцэх чиглэлд хэрэгжүүлж байгаа ажлын талаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас бэлтгэн хүргүүлж буй 2 дахь дугаарын тойм мэдээг хүлээн авна уу. Тус мэдээнд:

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын Брүүкингс институттай хийсэн уулзалт
- Ерөнхий сайдын хийсэн Авлигын талаарх мэдээлэл
- Хууль эрх зүйн шинэчлэл

## Засгийн газрын гишүүд Брүүкингс институттай уулзалт хийв.

- Өнгөрсөн долоо хоногт Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Соёлын сайд Ч.Номин болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл нар Брүүкингс институтын гишүүдтэй уулзалт хийв.
- Уулзалтын үеэр Хууль зүй, дотоод хэргийн сайд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Засгийн газрын хэрэгжүүлж буй “5 Ш” ажиллагааны талаар танилцуулав.
- Др. Даниел Кауфманн “Монгол Улс ардчиллын талаар бүс нутагтаа маш өндөр оноо авч байгаа нь гол давуу тал” гэдгийг онцлоод Монгол Улсын Засгийн газрыг авлигын суурь үндсэн шалтгаанд анхаарлаа хандуулах хэрэгтэй гэдэгтэй санал нэг байгаагаа илэрхийлэв.
- Цаашид Монгол Улсын Засгийн газар болон Брүүкингс институтын хооронд байнгын хамтын ажиллагаатай байхаар тохиролцов.



“Монгол Улс ардчиллын талаар бүс нутагтаа маш өндөр оноо авч байгаа нь гол давуу тал.”



Др. Даниел Кауфманн, Брүүкингс институтын Дэлхийн эдийн засаг, хөгжлийн асуудал хариуцсан Ахлах зөвлөх

## Авлига бол хүний эрхийн хамгийн том зөрчил

- Ерөнхий сайд хүний эрхийн чиглэлээр ажилладаг төр, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзалт хийж, хүний эрхийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудаар санал солилцов.
- Уулзалтад Хүний эрхийн үндэсний комиссын дарга оролцож, хүний эрхийн үндэсний индексийг боловсруулах шаардлагатай байгааг онцлов.
- Ерөнхий сайд Засгийн газрын авлигын эсрэг хэрэгжүүлж байгаа 5Ш арга хэмжээг танилцуулж, авлигатай тэмцэхдээ хүний эрхийн зөрчил гаргаагүй байхад анхаарна гэдгийг онцлоод иргэний нийгмийн байгууллагууд хяналтын үүргээ гүйцэтгэж хамтран ажиллахыг хүслээ.
- Уулзалтад ирсэн иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд Засгийн газрын авлигатай хийж буй тэмцлийг дэмжиж буйгаа илэрхийлж, хөгжлийн бэршхээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрх, амжиргааны түвшнээс доогуур өрхийн хүүхдийн сурч боловсрох эрх, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийн нэмэгдүүлэх зэрэг асуудалд анхаарал хандуулж ажиллахыг хүсэж саналаа илэрхийлэв.



# Монгол Улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаа

## Улс төрийн намын тухай болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл

- Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр хуралдаж, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхийг дэмжлээ
- Шинэчилсэн найруулгын төсөлд улс төрийн намын эрх, үүрэг, намд эвлэлдэн нэгдэх иргэний эрх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан байх, нам цахим орчинд үйл ажиллагаа явуулах, намын үйл ажиллагаанд хориглох зүйлийн талаар тусгасан.
- Мөн улс төрийн намыг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, сонгуулийн төв байгууллагын уламжилснаар Улсын дээд шүүх улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах, намын санхүүжилт илт тод болох, сахилга хариуцлага дээшлэх, санхүү болон үйл ажиллагааны тодорхой асуудлуудаар сонгуулийн төв байгууллагад тайланг гаргах замаар олон нийтийн хяналтыг сайжруулах чиглэлд зохицуулалт тусгагдсан байна.
- Түүнчлэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна.
- Байгалийн баялгийн олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод, хариуцлагатай байлгах зорилгоор тус хуулийн төслийг боловсруулаад байна. Хуулийн үйчлэх хүрээнд эрдэс баялгаас гадна амьтан, ургамал, ойн баялгийн ашиглалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хамаарууллаа.
- Хуулийн төсөлд төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудаас санал авч, саналыг нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна.

## Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

- Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр явуулж буй зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эхний хэлэлцүүлгийг зохион байгууллаа.
- Хэлэлцүүлэгт мэргэжлийн холбоод, танхимууд, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын 150 гаруй төлөөлөл оролцлоо.



## Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Төрийн өмч, хувьчлалын Ажлын хэсгийн 40 дэх удаагийн хурал

- Монгол Улсын Засгийн газраас авлигатай тэмцэх чиглэлд хэрэгжүүлж буй “Шүгэл” ажлын хэсгийн ахлагч, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоогоор ахлуулсан төлөөлөл Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Төрийн өмч, хувьчлалын Ажлын хэсгийн 40 дэх удаагийн хуралд оролцлоо.
- Хурлын үеэр Дэд сайд Б.Солонгоо төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр төлөвлөж буй бодлогын шинэчлэлийн талаар танилцуулга хийлээ.
- Цаашид төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, ил тод, нээлттэй болгох, төрийн өмчит компанийн үйл ажиллагаанд авлигын эрсдэлийг бууруулж, хяналтыг сайжруулах чиглэлээр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Компанийн сайн засаглал хариуцсан газартай хамтарч ажиллах чиглэлээр мөн санал солилцлоо.
- Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.